

ТОРГОНЫ ЗАМЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ: ЮЭЖИ БА ХҮННҮ

П. ДЭЛГЭРЖАРГАЛ

Товч агуулга. Торгоны замын үүсэл, хөгжлийг судлахдаа Юэжи, Хүннү зэрэг нүүдэлчдийн улсуудын гүйцэтгэсэн түүхэн үүргийг орхигдуулсаар ирсэн. Гэтэл юэжи, хүннүчүүд олон улсын худалдааны гол зам болох торгоны замын үүсэл, хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсэн байдаг. Хүннүчүүд гурван удаа томоохон дайн хийж, Юэжиг ялснаар торгоны замын ноёрхлоо баталгаажуулсан байна. Монголын төв нутгийг Турфан, Таримын сав нутгийн орнуудтай холбодог «Талын торгоны зам» нь Жужан улсын үед байсан төдийгүй худалдааны энэ зам нь Хүннүгийн үеэс үүсэлтэй хэмээн үзэж байна.

Суурин иргэншлийн нүүдэлчдийн нийгэмд үзүүлсэн нөлөөний асуудалд судлаачид ихээхэн анхаарал тавьсаар ирсэн. Ялангуяа, Дотоод Азийн нүүдэлчдийн хөгжилд хятадын соёлын үзүүлсэн нөлөөг судлаачид чухалчилж судалдаг билээ. Гэтэл Дотоод Азийн нүүдэлчид эртнээс индо-европчуудтай харилцаж, энэ харилцаа Евразийн түүхэнд чухал үүрэг гүйцэтгэж байжээ. Торгоны замд хяналтаа тогтоон баруун зүгийн орнуудтай харилцах нь Монголын эртний улсуудын эдийн засаг, соёлын хөгжилд чухал ач холбогдолтой байв. Торгоны замд ноёрхохын төлөөх Юэжи, Хүннү болон улмаар Хүннү, Хань улсын хоорондын тэмцэл үүнийг батлан харуулдаг. Евразийн олон улсын худалдааны замын үүсэл хөгжилд Дотоод Азийн нүүдэлчин улсууд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж болох юм. Гэвч олон улсын худалдааны замын үүсэлд хятадуудын гүйцэтгэсэн үүргийг хэт дөвийлгөн үнэлж, нүүдэлчин улсуудын үүргийг орхигдуулдаг түүх бичлэгийн хандлага хүчтэй хэвээр байна.

Евразийг холбосон олон улсын худалдааны зам (торгоны зам) хэзээ үүссэн бэ? Хүннүгийн өштөн дайсан гэдгийг олж мэдээд улмаар Их Юэжийг хайн Дундад Ази болон баруун бүс нутгийн улсуудаар аялан явсан Уди хааны элч Жан Цяний мэдээллээс ханьгийн хааны ордон анх удаа баруун зүгийн орнуудын талаар найдвартай бодит мэдээлэлтэй болсныг хятад сурвалжийн мэдээ баталдаг. Улмаар Хань улс нийтийн тооллын өмнөх¹ 121, 119 оны байлдаанд ялалт

¹ Нийтийн тооллын өмнөх гэдгийг хойшид НТӨ гэж товчилж тэмдэглэнэ.

байгуулснаар Ганьсугийн коридорыг хүннүгээс булааж авч, баруун зүгийн улс орнуудтай (Турфан, Таримын сав нутаг)² шууд хиллэх болсноор олон улсын худалдааны зам (хожим нь торгоны зам хэмээх болсон) үүссэн гэж ихэнх судлаачид үздэг. Гэтэл Евразийн ард түмнүүдийн эртний худалдаа нь номин, хаш зэрэг үнэт чулууны арилжаанаас үүсэлтэй болохыг судлаачид тэмдэглэсээр ирсэн. Евразийн анхны худалдааны замыг «хаш чулууны зам» хэмээн нэрлэж болох юм. НТӨ 645 оны үед хятадууд юэжичүүдээс хаш авдаг байсан нь сурвалжид тэмдэглэгдэн үлджээ. Эртний хятадуудын хэрэглэж байсан хаш нь одоогийн Шинжааны Хотаны хаш байсныг судлаачид тогтоосон ажээ³.

НТӨ IV-III зууны гэхэд Евразийг холбосон олон улсын худалдааны замд Юэжи, Хүннү зэрэг нүүдэлчид чухал үүрэг гүйцэтгэж байсан. Гэвч торгоны замын үүсэлд нүүдэлчдийн гүйцэтгэсэн үүргийн талаарх асуудалд судлаачид харьцангуй бага анхаарч иржээ. НТӨ IV-III зууны үед, Монгол нутагт Дунху, Хүннү, Юэжи нар зэрэгцэн оршиж байв. НТӨ 209 онд Хүннү гүрэн байгуулагдаж хүчирхэгжсэн нь Евразийн бүс нутгийн хүчний харилцаа, хүчний тэнцвэрт шинэ үеийг эхлүүлж, бүс нутгийн орнуудын цаашдын хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн. Хүннү гүрнээс баруун бүс нутгийн талаар явуулсан бодлогод Хүннү Юэжийн харилцаа гол нөлөөтэй байжээ. Хүннү, Юэжийн хооронд болсон гурван удаагийн дайн нь олон улсын худалдааны замд ноёрхохын төлөөх тэмцэл байсан хэмээн үзэж болно.

Энэ өгүүлэлд, Дотоод Азийн нүүдэлчдийн улсууд барууны орнуудтай харилцах нь яагаад чухал байсан бэ?, Хүннүчүүд торгоны замтай хаагуур, ямар замаар холбогдож байсан бэ?, Хүннү, Юэжийн 3 удаагийн байлдааны үндсэн шалтгаан юу вэ? зэрэг асуудалд анхаарлаа хандуулж торгоны замын үүсэл хөгжилд Хүннү, Юэжийн гүйцэтгэсэн үүргийг тодруулахыг зорьсон юм. Юэжи, Хүннүчүүд нь «торгоны зам»-ын үүсэлд гол үүрэг гүйцэтгэсэн хэмээн үзэж байна.

Индо-европчуудын миграци: Юэжи. НТӨ III зуун гэхэд Дотоод Азийн бүс нутагт Дунху, Хүннү, Юэжи улсууд зэрэгцэн оршиж байв. Хүннүгийн Түмэн шаньюйн үед (НТӨ ? – 209 он) хөрш Дунху, Юэжи улсууд хүчирхэгжин мандаж байжээ. “Түүхэн тэмдэглэл”-ийн 110 дугаар бүлэг, Хүннүгийн шастирт:

“Энэ үед Дунху (东胡 donghu) хүчирхэгжин, Юэжи (月氏 yuezhi) цэцэглэн мандаж байсан бөгөөд Хүннүгийн шаньюй (匈奴單于 xiongnu shanyu) Түмэн (头曼 touman) байв”⁴ хэмээжээ.

² Энэ нутгийг хятадууд “西域xiyu, Баруун орон” гэж нэрлэдгийг англиар Western Region хэмээдэг. Хожим барууны түүхчид Дорнод Туркестан гэх болсон.

Манж Чин гүрэн өөрийн захиргаанд оруулаад Шинжаан буюу шинэ хязгаар гэж нэрлэжээ.

Монголын эзэнт гүрний үед Зүүн Цагадайн улс төвлөрч байсан энэ газрыг Монголистан гэдэг байв. Иймд Турфан, Таримын сав нутаг гэдэг газар зүйн нэрийг хэрэглэв.

³ Xinru Liu. Migration and Settlement of the Yuezhi-Kushan – *Journal of World History*. Fall. 2001, Vol. 12, №. 2, p. 265

⁴ 史記 (shi ji), 第110卷, 第2887頁

Хятад сурвалжийн мэдээгээр НТӨ III зууны үед юэжи нар Хүннүгийн баруун талд Ганьсугийн Дуньхуан ба Цилян уулын хооронд нутаглан (始月氏居敦煌祁連間, shi yuezhi ju dunhuang qi lianxian) ихээхэн хүчирхэгжиж байв (月氏盛, yuezhi sheng)⁵. Сурвалжид Ганьсугаас Тэнгэр уул, Дуньхуан хүртэлх нутагт юэжичүүд оршин байсан хэмээн тэмдэглэсэн боловч түүнээс баруун тийшх бүс нутгийг юэжичүүд хянаж байсан хэмээн үзэж болно. Баруун бүс нутгаар Жан Цянь аялан явж, олон мэдээлэл цуглуулан буцаж ирэх хүртэл Хань улсын хааны ордон энэ бүс нутгийн талаар ойлголт, мэдээлэлгүй байсан учир хятад сурвалжид энэ талаар тодорхой тэмдэглээгүй бололтой. Түмэн шаньюйн үед Юэжи ихээхэн хүчирхэг байсан нь тодорхой бөгөөд Хүннүд дарамт шахалт үзүүлж, Түмэн шаньюй хүү Модунаа юэжийн барьцаанд өгөхөд хүрч байв. Юэжийн угсаа гарвацийн талаар судлаачдын санал нэгдмэл биш боловч тэднийг индо-европ хэлтэн байсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Юэжиг нүүдэлчин гэдгийг сурвалжид тодорхой тэмдэглэсэн боловч хэдий үеэс Ганьсугийн бүс нутагт суурьших болсон нь тодорхойгүй. Тиймээс индо-европ хэлтнүүд Ганьсугийн бүс нутагт шилжин суурьшсан асуудал ихээхэн сонирхолтой юм.

Байлдааны тэрэгт цэргийн технологийг индо-европчууд буй болгосноор тэд ихээхэн хүчирхэгжин тэлэх болж, дорно зүг нүүдэллэн индо-иран хэлтний томоохон бүлгийг үүсгэсэн билээ. Индо-европ хэлний баруун тийш тархсан Кельт, Герман, Грек (Celtic, Germanic, Greek) зэрэг европын хэлнүүдийг “centum” (Латинаар 100-г “centum” гэнэ), зүүн тийш Энэтхэгийг хүртэл тархсан Иран, Санскрит, Авестан (Iranian, Sanskrit, Avestan) зэрэг Азийн хэлнүүдийг (100-г Санскритаар “satam”, Авестийн хэлээр “satem”) “satem” гэж хоёр хувааж үздэг. Гэтэл Таримын сав нутаг буюу “satem” хэлний бүлгийн тархацтай бүс нутгаас “centum” бүлэгт хамаарах бичгийн дурсгал их хэмжээгээр олдсон нь эрдэмтдийн дунд маргаан үүсгэж, олон таамаглал дэвшүүлэхэд хүргэсэн ажээ. Тохар хэлний “А” аялгуугаар 100-г “känt”, харин “В” аялгуугаар “kante” гэх тул тус хэлийг индо-европ хэлний “centum” бүлэгт хамааруулжээ. Таримын сав нутаг дахь Куча, Карашар, Турфанаас Тохар хэлээрх их хэмжээний материал олдсон нь Тохарын асуудал, Тохар ба Юэжийн холбоо хамаарлын асуудал дэвшигдэхэд хүргэжээ⁶. Тохар хэлний асуудал нь Индо-европчуудын зүүн тийш хийсэн шилжилт нь нэг удаагийн нүүдэл бус, хэд удаа болсон, олон жил үргэлжилсэн үйл явц болохыг харуулж байна.

Түүнчлэн Таримын сав, улмаар Дуньхуан, Ганьсугийн бүс нутагт индо-европ хэлтнүүд хаанаас, хэдий үед ирж анх суурьшсан асуудал нь маргаантай байдаг. Судлаачид хүрэл зэвсгийн дунд үеэс индо-европ хэлт Афанасевчууд өмнөд Оросын тал нутгаас Алтай, Енисейн бүс нутаг руу шилжин нүүж, НТӨ III мянганы дунд үед Андроновын соёлтой нэгдэн нийлж, улмаар НТӨ II мянганы эхээр тэд дахин нүүдэллэж Ганьсу, Таримын сав газар ирж суурьшсан гэж

⁵ 史記 (shi ji), 第123卷, 第3162頁

⁶ Дэлгэржаргал П. Хүннү ба Юэжи 月氏, Усунь 烏孫-ий харилцаа – *Studia Historica*. Tom. XLIII-XLIV. Fasc. 3. УБ., 2015. 46-57-р талаас дэлгэрүүлж харна уу

үзэх болсон⁷. Хятад сурвалжид Юэжи нэрээр тэмдэглэгдсэн ард түмэн эртний Грек сурвалжид Тохар нэрээр тэмдэглэгдсэн бөгөөд тэд Таримын сав нутагт индо-европ хэлийг өргөн тархаасан гэдэг саналыг судлаачид дэвшүүлэх болов. Юэжи болон Тохар хоёрыг адилтгаж байгаа энэ саналын гол үндэслэл нь хэл шинжлэлийн баримт юм⁸.

Түүнээс гадна Юэжиг Скифээс гаралтай хэмээн үзэж Алтайн бүс нутаг нь Юэжийн эзэмшилд байсан тул Пазырыкийн соёлыг Юэжид хамруулан үзэж, “салангид Скиф” нь Пазырыкийн соёлыг үүсгэсэн бөгөөд тэд нарыг өвөг-Юэжи нар байсан гэж зарим судлаачид үздэг⁹. Ийнхүү Юэжийн угсаа гарвалын талаар судлаачдын санал нэгдмэл биш боловч тэднийг индо-европ хэлтэн байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх болжээ.

Индо-европчуудын нүүдэл нь НТӨ III зуунаас өмнө, Ганьсугаас Тэнгэр уул, түүнээс баруун тийшх бүс нутагт индо-европ хэлтэн давамгайлж байсныг харуулна. Иймээс Евразийг холбосон олон улсын худалдааны замын үүсэл нь индо-европчуудын миграцитай салшгүй холбоотой хэмээн үзэж байна. Ялангуяа, Ганьсу, Дуньхуаны бүс нутгаар төвлөрөн, олон улсын худалдааны замын зангилаа дээр оршиж байсан юэжичүүд торгоны замын үүсэлд чухал үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой юм.

Харин Хүннү гүрэн хүчирхэгжсэнээр индо-европ, индо-иранчуудын Зүүн Ази дахь тэлэлтийг зогсоосон төдийгүй, тэднийг баруун тийш буцаан шахсан ажээ. Хүннүчүүд Юэжи рүү НТӨ 208, 177, 167 оны орчим гурван удаа довтолгон томоохон ялалт байгуулжээ. Хүннү, Юэжийн хоорондох гурван удаагийн дайн нь Евразийн торгоны замд хэн нь ноёрхохыг шийдэх улс төр, геополитикийн чухал учир холбогдолтой байлдаан байжээ. Евразийн олон улсын худалдааны замын үүсэл хөгжилд Юэжи, Хүннү зэрэг нүүдэлчин угсаатнууд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байна.

Хүннү, Юэжийн гурван дайн: Хүннүгийн хүчирхэгжилт. Модунь НТӨ 209 онд хүннүгийн шаньюй болж, Хүннү хүчирхэгжиж эхэлжээ. Хүннү гүрэн хүчирхэгжсэнээр Евразийн бүс нутагт хүчний шинэ хуваарилалт болж, олон улсын худалдааны замд хяналтаа тогтоохын төлөөх тэмцэл өрнөсөн юм. Хүннү, Юэжийн гурван удаагийн дайнд Хүннү нар ялснаар Дотоод Азийн бүс нутагт дангаараа ноёрхож, олон улсын худалдааны замд хяналтаа тогтоох боломжтой болсон байна. Энэ нь урт удаан үргэлжилсэн өрсөлдөөн тэмцэл, дайн байлдааны ялалтын үр дүнд байв.

- Модунь хүннүгийн шаньюй болоод Дунхуг довтолж бут цохисны дараа шууд Юэжиг довтолсон ажээ. Энэ бол Хүннүгээс Юэжиг довтолсон анхны дайн юм.

⁷ Craig G.R. Benjamin. The Yuezhi: Origin, Migration and the Conquest of Northern Bactria. Brepols, 2007. pp. 25-27

⁸ Pulleyblank E.G. Chinese and Indo-Europeans – *Journal of the Royal Asiatic Society of Great Britain and Ireland*. №1/2. London, 1966. pp. 12-22, 36

⁹ Enoki K., Koshelenko G.A., Haidary Z. The Yüeh-chih and their migrations – *History of Civilization of Central Asia*. Vol. II. UNESCO Publishing, 1994. pp. 177-178

“Түүхэн тэмдэглэл”-ийн Хүннүгийн шастирт:

“Тэрээр [Дунхуг эзлэн] буцаж ирээд, баруун тийш Юэжиг довтлон бут ниргэж, өмнө зүг Лоуфань (樓煩 loufan), Байяны хэнань ван (白羊河南王 bayang henenwang)-г эзлэв. Циньгийн Мэн Тяний эзэлсэн Хүннүгийн газар нутгийг эргүүлэн авав”¹⁰ хэмээжээ.

Энэ дайнд Модунь шаньюй ялалт байгуулсан нь тодорхой боловч Юэжи нар баруун тийш нүүсэн тухай тэмдэглэсэн зүйл байхгүй. Энэ дайны үр дүнд, Ганьсу, Дуньхуаны бүс нутагт Хүннү гүрэн ноёрхлоо тогтоон, торгоны замыг хянах болсон нь тодорхой боловч түүнээс цааших худалдааны замд хэр их нөлөөтэй болсон нь тодорхойгүй.

- Юэжийн эсрэг Хүннүгийн хийсэн хоёр дахь довтолгооны талаар НТӨ 176 онд Модунь шаньюйгаас Хань улсын хаанд бичсэн захидалд:

“Тэнгэр заяат Хүннүгийн их шаньюйгаас хуанди (хаан)-ын амгаланг ирж мэндчилье. Урдах хаан энх ургаар больё хэмээсэн бүлгээ.. .. Хань улсын хязгаарыг баруун сэцэн ван халдан довтолжээ. Баруун сэцэн ван зөв суралгүй Хоу Илухоу (後義廬侯 houyiluhou) нарын арганд унаж, хоёр эзний тангаргийг тасалж, ах дүүгийн ёсыг огооров.. ..Бага түшмэл эв эвдсэн тул баруун сэцэн ванг баруунш Юэжиг дайл хэмээн илгээв. Эцэг тэнгэрийн ивээлээр, эрэлхэг дайчдын сайнаар, хүлэг морьдын шандас хүч чадлаар Юэжиг номхотгон дарав. Эвээр больё гэснийг нь энэрч, эсэргүүцсэнийг нь цавчив. Лоулань (樓蘭 loulan), Усунь (烏孫 wusun), Хузе (呼揭 huji) зэрэг хол ойрын хорин зургаан улс (二十六國 ershiliugo)-ыг хураан авч нэгтгэн захирлаа. Өдгөө тэд Хүннүгийн албат болжээ. Ийнхүү нум сумтан ард түмэн бүгд нэгэн их гэр бүлд багтаад, хойд нутагт энх амгалан ёс тогтов. Хүлэг морьдын нурууг амрааж, эрэлхэг дайчдынхаа ядаргааг тайлъя, өмнөх хэргийг огоорч, урьдах гэрээг сэргээе...”¹¹ хэмээжээ.

Хүннүгийн энэ довтолгоо нь Юэжи болон баруун бүс нутгийн орнуудын эсрэг хийсэн өргөн цар хүрээтэй дайн байсан нь тодорхой байна. Захидалд дурдсанаар, баруун сэцэн ван Юэжиг бут цохин, Лоулань, Усунь, Хузе болон Таримын сав нутгийн 26 улсыг эзлэн авч, Хүннү гүрэн газар нутгаа ихээхэн өргөтгөжээ. Ийнхүү Таримын сав нутаг, Дундад Азийн торгоны замын үлэмж хэсэгт Хүннү нар хяналтаа тогтоосон байна. Байлдаанд ялагдсан Юэжи нар зугтаж, Тэнгэр уулын ар, Или голын хөвөөнд очиж суусан гэж судлаачид үздэг. Энэ байлдааныг хүртэл Юэжи нар торгоны замд тодорхой нөлөөтэй хэвээр байсан гэж үзэж болно.

- Лаошан шаньюйн үед болсон Хүннүгийн гурав дахь довтолгоо Юэжид ихээхэн хохирол учруулсан бөгөөд Юэжийн ванг алж, түүний толгойн гавлаар аяга хийсэн ажээ. Лаошан шаньюйн хийсэн довтолгооны тухай “Түүхэн тэмдэглэл”-ийн Хүннүгийн шастирт тодорхой өгүүлээгүй. Харин Уди хааны элч Жан Цянь эргэж ирээд эзэн хаанд өргөн барьсан Юэжийн талаарх илтгэлийг “Даюаний тэмдэглэл”-д оруулсан нь ихээхэн үнэ цэнтэй түүхийн баримт билээ.

¹⁰ 史記 (shi ji), 第110卷, 第2887頁

¹¹ 史記 (shi ji), 第110 卷, 第2896頁

Түүнд:

“Их Юэжи нь Даюаниас баруун тийш 2000-3000 ли газарт Гүйшүй голын умард хэсэгт оршдог. Тэд өмнө талаараа Дасятай, баруун талаараа Аньси-тай, умард зүг Канжү-тай хиллэнэ. Тэд бол нүүдэлчин угсаатан, малаа хариулан нэг газраас нөгөө газар руу нүүдэг, тэдний зан заншил Хүннүтэй адилхан. Тэд 100-200 мянган нум сумт дайчидтай. Хуучин тэд ихээхэн хүчирхэг байхдаа Хүннүг тоодоггүй байв. Модуний үед Хүннү хүчирхэгжин, тэр Юэжиг довтлон ялсан. Лаошан Хүннүгийн шаньюй байх үед тэд Юэжийн ванг алж, түүний гавлын ясаар гавал аяга хийжээ. Угаасаа юэжи нар Цилян, Тэнгэр уул ба Дуньхуаны хооронд сууж байсан. Гэвч Хүннүд ялагдсаны дараа тэд алс хол нүүж, Даюанийг өнгөрч, баруун зүгт Дася руу довтлон эзлэв. Дараа нь Гүйшүй (Амударьяа мөрөн) голын умард хөвөөнд нийслэл байгуулж, тэнд ван нь суух болсон”¹² гэжээ.

“Түүхэн тэмдэглэл”-ийн мэдээг баримталбал, Хүннү, Юэжийн гурав дахь удаагийн дайн Лаошан шаньюйн үед болсон бөгөөд энэ удаагийн байлдаанд Юэжийн ван алагдаж, тэдэнд үлэмж хохирол учруулсан. Ялагдсан юэжи нар дахин баруун тийш зугтаж, Аму-дарьяа мөрний хөвөөнд очиж суужээ.

“Түүхэн тэмдэглэл”-ийн 123 дугаар бүлэг “Даюаний тэмдэглэл”-д Жан Цянь баруун бүс нутгаар хэрхэн аялсан, тэдгээр орны байдал, газар нутаг, эрхлэх аж ахуй, соёлын талаар дэлгэрэнгүй тэмдэглэн үлдээсэн нь хятадын түүх бичлэг дэх Дундад Ази, Таримын сав нутгийн орнуудын талаарх анхны мэдээ юм. Сыма Цянь тухайн цаг үед амьдарч, “Түүхэн тэмдэглэл”-ийг бичиж байсан тул Жан Цяний хаанд өргөсөн илтгэлийг сурвалж болгон ашигласан төдийгүй Жан Цяньтай уулзаж яриаг нь тэмдэглэн авах боломжтой байсан нь тодорхой юм.

“Түүхэн тэмдэглэл”-ийн дээрх мэдээ нь “Хань улсын судар”-ын 96 дугаар бүлгийн мэдээтэй тохирдог. Тухайлбал:

“Их Юэжи бол угтаа нүүдэлчин улс, хүмүүс нь мал сүрэгтэйгээ нэг газраас нөгөөд нүүж явдаг, зан үйл Хүннүтэй адил. Арав илүү түмэн нум татагчтай, чийрэг учир Хүннүг басамжилдаг байсан. Анх Дуньхуан Циляний хооронд суудаг байсан. Модунь шаньюй Юэжиг бутцохиж, Лаошан шаньюй түүнийг алж, гавлаар нь аяга хийсэн. Тэгэхэд Юэжи өрнө зүгт зайлж Даюаниар өнгөрч, Дася-г довтолж, эзэлсэн. Гүйшүй-н хойно вангийн ордон байгуулсан”¹³ гэж тэмдэглэсэн байна.

Энэ мэдээ нь Лаошан шаньюйн үеийн Хүннүгийн довтолгоонд Юэжи томоохон ялагдал хүлээж, тэдний ван алагдсан гэдэг “Түүхэн тэмдэглэл”-ийн мэдээг баталж байна. Энэ байлдаан болсон жил тодорхойгүй боловч НТӨ 167 оны үед Юэжийн эсрэг дайн болсон хэмээн үзэж болно. Хүннүд ялагдсан Юэжи нар баруун тийш зугтан нүүсэн бөгөөд Даюанийг өнгөрч, Дася буюу Бактри улсыг эзэлж, Аму-дарьяа мөрний хөвөөнд очиж суусан нь нэлээд хожим НТӨ 130-аад оны хэрэг явдал юм.

Хань улс баруун бүс нутгийн орнуудтай харилцах болсон үеэс Таримын сав нутаг дахь Хүннүгийн ноёрхол, нөлөөг сулруулж, өөрийн нөлөөг тогтоох бодлого

¹² 史記 (shi ji), 第123卷, 第3161-3162頁

¹³ 漢書 (han shu), 第96卷, 第3890-3891頁

явуулах болсон. Хань улс Хүннүгийн хооронд олон жил үргэлжилсэн торгоны замд ноёрхохын төлөөх тэмцэл ийнхүү эхэлсэн түүхтэй бөгөөд энэ бодлогоо “Хүннүгийн баруун гарыг таслах бодлого” хэмээн нэрлэж байв.

Хожмын “Хань улсын судар”, “Хожуу Хань улсын судар”-ын энэ үеийн талаарх мэдээнүүд “Түүхэн тэмдэглэл”-ээс хуулбарласан шинжтэй бөгөөд харин цаашид үргэлжлүүлэн бичсэн байдаг. Ийнхүү бичихдээ зарим мэдээг засварлан өөрчилсөн. Үүний шалтгааныг судлаачид өөр өөрөөр тайлбарладаг билээ. “Хань улсын судар”-ын эх хэрэглэгдэхүүнийг цуглуулсан гэх Бань Бяо болон “Хань улсын судар”-ыг зохиогч Бань Гу нар хожим амьдарч байсан хүмүүс тул тэдний “Түүхэн тэмдэглэл”-ийн мэдээн дээр нэмж бичсэн зүйлүүдийг¹⁴ засварласан шинжтэй хэмээн үзэж болох юм.

Жан Цянь НТӨ 118-115 онд Хань улсын элч нарыг ахлан баруун орнуудаар дахин элчээр явахдаа их хэмжээний бэлэг сэлт, тансаг эд бараа авч явжээ. Усуньд хүрч Куньмо вантай уулзаж, бэлэг сэлтээ өгч, Хүннүгийн эсрэг холбоотон болохыг ятгасан ч, усуньчууд хүлээн зөвшөөрсөнгүй. Гэвч Усунь болон Таримын сав нутгийн орнуудтай холбоо тогтоон, тэдний зарим элчийг дагуулан Хань улсад эргэн ирсэн байдаг. Энэ бол баруун бүс нутгийн орнуудаас Хань улсад ирсэн анхны элч төлөөлөгчид байв. Хятад сурвалжийн энэхүү мэдээг үндэслэн торгоны замыг Уди хааны үед үүссэн гэж үзэх нь учир дутагдалтай юм. Үүнээс өмнө Юэжи, Хүннү нар Таримын савын орнууд ба Хань улсын хоорондох Ганьсу, Дуньхуаны нутагт ноёрхон, олон улсын худалдааны замыг хянаж байсан ажээ. Уди хааны үеийн дээрх үйл явдал нь Хань улсаас баруун бүс нутгийн улсуудтай анх холбогдсон тухай тэмдэглэл юм. Турфан, Таримын сав нутгийн орнуудын талаар Хань улсын хааны ордон ямар ч мэдээлэлгүй байснаас үзэхэд олон улсын худалдааны замын талаар ч тэд ойлголтгүй байсан хэмээн үзэж болно.

Юэжийн нүүдлийн талаарх “Түүхэн тэмдэглэл” болон “Хань улсын судар”-ын мэдээг харьцуулж үзвэл, Хүннү, Юэжийн гурван удаагийн дайн нь торгоны замд ноёрхохын төлөөх тэмцэл байсан гэж үзэж болохоор байна. Гурван дайнд Хүннү гүрэн ялснаар Таримын сав төдийгүй Дундад Азийн үлэмж нутагт ноёрхлоо тогтоон, торгоны замыг хянах болжээ. Хүннүд ялагдсан Юэжичүүд торгоны замын нэгэн гол зангилаа Амударьяа мөрний савд очин сууж, Кушаны хаант улсыг байгуулсан нь тэдний хувьд торгоны зам чухал ач холбогдолтой байсныг дам харуулах баримт юм.

Хүннүчүүд Тунпү Дүвэй буюу жанжны газар байгуулан Турфан, Таримын сав нутгийг шууд харьяалан захирч, татвар авч байжээ. Хань улсын судрын 96 дугаар бүлэг “Баруун орны шастир”-т:

“Хуучин тэд Хүннүгийн албат байсан. Хүннүгийн баруун захад Жижү (日逐rizhu) ван Тунпү Дүвэй (僮僕都尉tongpu duwei) байгуулан Баруун орныг шууд захирдаг.

¹⁴ Дэлгэржаргал П. Хүннү ба Юэжи月氏, Усунь烏孫-ий харилцаа. *Studia Historica* – Tom. XLIII-XLIV. Fasc. 3. УБ., 2015. т. 46-57 өгүүллээс Түүхэн тэмдэглэл болон Хань улсын судрын зөрөөтэй мэдээний талаар дэлгэрүүлж үзнэ үү.

Тэрээр Яньци (焉耆yanqi), Вэйшү (危須weixu), Вэйли (尉黎weili)-ийн нутагт байнга сууж, бусад орноос татвар хураан, баялгийг Янь [ци] руу аваачдаг байсан”¹⁵ хэмээжээ.

Сурвалжийн дээрх мэдээнээс үзвэл, Баруун бүс нутгийг захирах хүннүгийн жанжны газар (Тунпү Дүвэй) нь Яньци (Карашар)-ийн ойролцоо байсан бөгөөд Таримын сав нутгийн орнуудаас татвар хураан, эд баялаг цуглуулдаг байжээ. Хүннүгийн Тунпү Дүвэй нь Яньци болон Турфаны хооронд, Яньци-аас холгүй байсан гэж үзэж болно. Хүннү гүрэн Турфан Хами-аар дамжин торгоны замаар баруун зүгийн орнуудтай холбогдох нь стратегийн чухал ач холбогдолтой байсан.

Монголын төв нутгийг Хами, Турфантай холбодог худалдааны замын талаар хятад сурвалжид нэлээд хожуу тэмдэглэгдсэн бөгөөд «Хуйхуй зам» буюу «Уйгурын зам» хэмээн нэрэлдэг билээ. Сурвалжийн энэ мэдээнд үндэслэн, Турфан, Таримын сав нутгийг Орхоны хөндий буюу Монголын төв нутагтай холбосон худалдааны зам Уйгурын үед үүссэн гэдэг түүх бичлэгийн хандлага тогтсон ажээ. Гэтэл V зууны эхэн үе гэхэд Жужан улс нь Турфан, Таримын сав нутагт ноёрхлоо тогтоон, торгоны замыг хянаж байсан нь сүүлийн үеийн судалгаагаар нотлогдож байна. 1997 онд Турфанаас олдсон “элчийн бүртгэл тэмдэглэл”-ийн мэдээнээс үзвэл, Таримын савын Куча, Яньциас Турфан дахь Гаочаны ванлигаар дайран Жужан улс руу явдаг «талын торгоны зам»-ын салаа зам байсан нь тодорхой байна.

Турфан, Хами-аас Тэнгэр уулын салбар уулыг даван одоогийн Говь-Алтай аймгийн нутаг руу орж ирдэг «талын торгоны зам» нь жужанчууд Таримын савын орнууд, Дундад Ази, умард Энэтхэг, өмнөд хятадын улсуудтай харилцах гол зам байсан ажээ. Турфан, Таримын сав нутгийн орнуудтай Жужанчууд харилцах гол түшиц газар нь Турфан дахь Гаочаны ванлиг байжээ. Гаочаны ван нь Жужан улсын элчийг хүрэх газарт нь хамгаалан саадгүй хүргэх, унаа агт, хоол хүнс, орон байраар хангах үүрэг хүлээдэг байсан байна. Элчийн бүртгэлийн явах чиглэлд “умард уул” хэмээн тэмдэглэсэн нь Жужан руу явах замыг буюу Тэнгэр уулын салбар болох Богд уулыг хэлж байгаа нь тодорхой юм¹⁶. Элчийн бүртгэлд дагалдан явах хүн (улаач), унаа агт, хоол хүнс, орон байраар хангах үүргийг Гаочан ванлиг хүлээж байснаас үзэхэд “умард уул” гэдэг нь явах өртөөний чиглэлийг зааж байгаа нь тодорхой юм. Элчийн бүртгэл тэмдэглэлээс үзвэл, Жужан улсаас Турфан дахь Гаочанаар дайран Яньци, Куча ордог өртөө зам байжээ. Өртөө зам нь «талын торгоны зам»-ын дагуу Монголын эртний улсуудын үед үүссэн бөгөөд тухайлбал, Жужан улсын үед байсны нотолгоо хэмээн үзэж байна.

Түүнчлэн Говь-Алтай аймгийн Шарга сумын нутгаас Чингай балгасыг илрүүлэн судалсан Монгол Японы эрдэмтдийн судалгаагаар V-VII зууны үеийн

¹⁵ 漢書 (han shu), 第96卷上, 第3872頁

¹⁶ Дэлгэржаргал П. Торгоны замд ноёрхохын төлөөх Жужан улсын тэмцэл – Historia Mongolarum. Tom. XIX, Fasc. 2, №19 (546) 2020. т. 11-22

соёлт давхарга илэрсэн ажээ¹⁷. Дээрх судалгаа нь Хорезмын эсрэг аян дайнд Чингис хааны их цэрэг «талын торгоны зам»-аар явсан гэсэн дүгнэлтэд хүргэж байгаа нь чухал юм. Энэ зам Монголын их цэргийн хангамж, ложистикт чухал үүрэгтэй байсан байх нь. Жужаны үед байсан худалдааны зам буюу «талын торгоны зам»-ыг бүр Хүннүгийн үеэс Хүннү ба Турфан, Таримын бүс нутгийг холбодог торгоны гол зам байсаар ирсэн хэмээн үзэх нь зүйтэй санагдана. Хүннүгийн Тунпү Дүвэй (жанжны газар)-гийн цэрэг, Жижү вангийн орд өргөө, албат нар нь шаньюйн орд өргөөтэй байнга харилцах, Таримын сав нутгийн орнуудаас хураасан татварыг шаньюйн ордонд аваачих, Барууны орнуудтай харилцаж худалдаа арилжаа хийх шаардлагын улмаас Яньци-аас Турфанаар дамжин Хүннү хүрдэг торгоны замын нэгэн салаа зам байсан нь хэмээн үзэж байна. Ер нь баруун бүс нутгийг Хүннү, Жужантай холбодог энэхүү замаас гадна Турфан, Өрөмчөөс Алтайн нурууг Бодончийн хавцлаар даван Ховд аймгийн Булган сумаар орж ирдэг бас нэгэн зам эдүгээ ч байсаар байгаа билээ. Хүннүгийн археологийн малтлагаас Барууны орнуудаас гаралтай олдвор ихээр олддог нь Хүннү ба Барууны орнууд өргөн дэлгэр харилцаатай байсныг нотолдог. Энэхүү харилцааны гол зам нь Яньци, Турфанаас одоогийн Ховдын Булганаар, эсвэл Хамигаас Тамчийн даваагаар Алтай нурууг даван одоогийн Говь-Алтайн Шарга говиор дайран Хүннүгийн нутагт хүрдэг хэмээн төсөөлж байна. Тиймээс Хами, Турфаны умард торгоны замтай Монголын төв нутгийг холбосон торгоны замын умард салаа болох “талын торгоны зам”-ыг Хүннүгийн үед буй болсон байх ёстой гэж үзэж байна.

Дүгнэлт

- Эртнээс Евразийг холбосон олон улсын худалдаа зам (хожим торгоны зам гэх болсон) нь Дотоод Азийн нүүдэлчдийг баруун зүгийн орнуудтай холбох гол зам болж Евразийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж байжээ.

- Торгоны замын үүсэл хөгжилд Юэжи, Хүннү улсууд чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ. Евразийг холбосон олон улсын худалдааны замын үүсэл нь Индо-европчуудын нүүдэлтэй салшгүй холбоотой бөгөөд Ганьсугийн бүс нутагт суурьшсан юэжичүүд чухал үүрэг гүйцэтгэсэн хэмээн үзэж байна.

-Хүннү нар Юэжийн эсрэг 3 удаа дайн хийж, ялалт байгуулснаар Торгоны замд өөрийн ноёрхлыг тогтоосон ажээ. Хүннү, Юэжийн 3 удаагийн дайны гол шалтгаан нь торгоны замд ноёрхохын төлөөх тэмцэл байсан хэмээн үзэж байна. Дайнд ялалт байгуулан индо-европчуудын түрэлтийг зогсоон, буцаан шахсанаар Хүннү гүрэн Евразийн хүчирхэг гүрэн болж, Алтай хэлт нүүдэлчид энэ бүс нутагт хүчирхэгжих үндэс суурь болсон ажээ.

- Торгоны замыг Уди хааны үед Хань улс Хүннүгээс Хэси нутгийг булаан авч, Баруун оронтой шууд хиллэх болсноор үүссэн гэдэг нь батлагдахгүй байна. Түүнээс өмнө юэжичүүд, улмаар Хүннү гүрэн Ганьсу, Турфан, Таримын сав

¹⁷ Наката Ю, Мураока Х. Алтайгаас олдсон Монголын эзэнт гүрний үеийн бурхан, түүний ач холбогдол. УБ., 2019

нутагт ноёрхлоо тогтоон, олон улсын худалдааны замыг үүсгэн хөгжүүлж, хяналтаа тогтоож байжээ.

-Турфан, Хамийг дайран өнгөрдөг торгоны умард замыг Монголын төв нутагтай холбосон «талын торгоны зам» нь Жужаны үед чухал үүрэгтэй байсныг “элчийн бүртгэл тэмдэглэл”-ийн мэдээ нотолж байна. Турфан дахь Гаочаны ванлиг нь элчийг дагалдан хүргэх хүн (улаач), агт морь, хүнс хоол, орон байраар хангах үүрэг хүлээж байсан нь Турфанаас Жужан ордог “өртөөний алба” байсны баримт хэмээн үзэж байна. Энэ зам нь Жужаны улс төр, эдийн засаг, соёлын харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байсан төдийгүй бурхны шашин болон умард Энэтхэгийн соёл, бичиг үсэг Монгол нутагт нэвтрэх гүүр болж байжээ.

- Турфан, Хами-г монголын төв нутагтай холбож байсан Торгоны замын умард салаа болох «талын торгоны зам» нь Жужаны үед байсан төдийгүй, Хүннүгийн үеэс үүсэлтэй хэмээн үзэж байна. Карашар дахь Яньци-ийн ойролцоо Хүннү гүрэн Тунпү Дүвэй буюу жанжны газар байгуулан, Таримын савын орнуудыг шууд захирч, татвар авдаг байсан. Хүннү гүрэн нь Таримын сав нутгийн орнууд болон баруун зүгийн орнуудтай худалдаа хийх, элч солилцох, авсан татвараа шаньюйн орд өргөөнд хүргэх зэрэг зайлшгүй шаардлагын улмаас Турфаныг Монголын төв нутагтай холбосон «талын торгоны зам» Хүннүгийн үед бий болсон хэмээн үзэж байна.

- Талын торгоны зам нь хүннү, жужанчуудын хувьд эдийн засаг, худалдаа, соёлын зам төдийгүй цэрэг стратегийн чухал үүрэгтэй байсан. Тиймээс талын торгоны замын дагуу “өртөөний алба”-ыг үүсгэн хөгжүүлсэн бололтой бөгөөд энэ алба нь төрийн чухал элч төлөөлөгч солилцох, татвар хураах зэрэгт үйлчилдэг байсан бололтой.

Abstract

The pivotal historical contributions of nomadic states such as the Yuezhi and Xiongnu have been underappreciated in the exploration of the origins and evolution of the Silk Road. This article endeavors to illuminate the significant role played by these states in shaping the Silk Road. Highlighting the crucial involvement of the Yuezhi and Xiongnu, the study reveals their integral role in the inception and advancement of the primary international trade route known as the Silk Road. Furthermore, it posits that the “Steppe Silk Road,” linking the central region of Mongolia to the cities and states of the Turfan and Tarim basins, not only emerged during the Rouran period but also traces its origins back to the Xiongnu Empire.